

## УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗОГСООЛ АЖИЛЛУУЛАХ, ТӨЛБӨР АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт нийтэд үйлчлэх тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар батлагдсан барилга, зам талбайн төлбөртэй зогсоолын эрэлт, нийлүүлэлтийг зохицуулж, эдийн засгийн эргэлтэд оруулах, замын хөдөлгөөний түгжрэл, саатал, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг дэмжих, орчны бохирдлыг бууруулах, нийтийн тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор нэгдсэн удирдлагын системээр зохицуулах, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг тодорхойлох, үйлчилгээ эрхлэх байгууллага (цаашид "үйлчилгээ эрхлэгч" гэх) болон төлбөртэй зогсоолоор үйлчлүүлэгчийн (цаашид "үйлчлүүлэгч" гэх) хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Энэхүү журам нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Иргэний хууль, Авто замын тухай, Авто тээврийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 1.3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт нийтэд үйлчлэх тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар батлагдсан барилга зам талбай дахь авто зогсоол (цаашид зогсоол гэх)-ын үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ хариуцах бөгөөд Нийслэлийн Зам, Газар зохион байгуулалт, Татвар, Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналт, Хотын стандарт хариуцсан байгууллагууд холбогдох чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллана.
- 1.4. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт зогсоолын талбайгаас төлбөр авч байгаа бүх үйлчилгээ энэхүү журмын дагуу зохицуулагдана.

### Хоёр.Хамрах хүрээ, эрх үүрэг

- 2.1. Энэхүү журмын хамрах хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт нийтэд үйлчлэх тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар батлагдсан барилга, зам талбай дахь төвлөрсөн ил болон дотор зогсоол, гудамж зам дагуух зогсоол хамрагдана.
- 2.2. Улаанбаатар хотод мөрдөгдөх зогсоолын төлбөрийн хэмжээг бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.<sup>1</sup>

<sup>1</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль ...35.1.10.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох; ...48.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн, баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар батална.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль ...16.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь татварын хууль тогтоомжоор эрх олгож, тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтооно.

Авто замын тухай хууль ...30.1.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг Засгийн газар, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.

- 2.3. Зогсоолын байршил, нөхцөл, төлбөрт цагийн хуваарь, нийтийг хамарсан арга хэмжээ, амралтын өдрийн зохицуулалтын хэм хэмжээг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч тогтооно.<sup>2</sup>
- 2.4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нь зогсоолын үйлчилгээний төлбөрийн орлогыг хуваарилах хэм хэмжээг тогтооно.<sup>3</sup>

## Гурав. Нэр томьёо

### 3.1 Нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

- 3.1.1. “Тээврийн хэрэгслийн зогсоолын нэгдсэн удирдлага” гэж тээврийн хэрэгслийн зогсоолын байршил, дүүргэлтийн мэдээлэл, хяналт, зөрчил илрүүлэлт, төлбөрийн мэдээлэл зэрэг тээврийн хэрэгслийн зогсоолын талаарх бүх мэдээллийг хамруулсан цогц системийг;
- 3.1.2. “Тээврийн хэрэгслийн зогсоол” гэж тээврийн хэрэгслийг байршуулах, хадгалах зориулалттай, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу байгуулсан тэмдэг, тэмдэглэл бүхий талбай, барилга, байгууламж эсхүл тэдгээрийн хэсэг, дотор болон гадна хэсэгт өргөтгөж, суурилуулсан тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалттай тусгай байгууламжийг;
- 3.1.3. “Гудамж зам дагуух хаалтгүй зогсоол” гэж явган зорчигчдын болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийг бууруулахааргүй байхаар байгуулагдсан, гудамж зам дагуух төлөвлөгдсөн тээврийн хэрэгслийн зогсоолыг;
- 3.1.4. “Төвлөрсөн ил зогсоол” гэж тээврийн хэрэгслийг тодорхой хугацаанд үнэ төлбөргүй болон төлбөртэй нөхцөлөөр хадгалах зориулалтаар байгуулж, зориулалтын дагуу тохижуулсан талбайг;
- 3.1.5. “Төвлөрсөн дотор зогсоол” гэж тээврийн хэрэгслийг тодорхой хугацаанд үнэ төлбөргүй болон төлбөртэй нөхцөлөөр хадгалах зориулалтаар байгуулж, тохижуулсан барилга, байгууламжийг;
- 3.1.6. “Орон сууцны хороолол дундах зогсоол” гэж орон сууцны хороолол дунд оршин суугчдын тээврийн хэрэгслийг байршуулахаар төлөвлөж тохижуулсан талбайг;
- 3.1.7. “Тээврийн хэрэгслийг байршуулах бүрэн автоматжуулсан төхөөрөмж” гэж тээврийн хэрэгслийг автоматжуулсан төхөөрөмжийн тусламжтайгаар хүний оролцоогүйгээр босоо, хэвтээ чиглэлд зогсоолд шилжүүлдэг тоног төхөөрөмжийг;

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хууль ...28.1.2.гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;

**Авто замын тухай хууль** ...12.1.8.харьяа нутаг дэвсгэртээ авто замын хөдөлгөөнийг зохих хууль, журмын дагуу зохион байгуулах, зохицуулах;

**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль** ...9.5.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний акт гаргаж болно.

<sup>3</sup> **Авто замын тухай хууль** ...12.1.3.нийслэл, орон нутгийн чанартай авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах ажлыг зохион байгуулах;

- 3.1.8. “Зогсоолын үйлчилгээ эрхлэгч” гэж үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгслийг тодорхой хугацаагаар байршуулах, хадгалахаар зогсоол ажиллаж буй иргэн, хуулийн этгээдийг;
- 3.1.9. “Зогсоол эзэмшигч” гэж өөрийн болон нийтийн эзэмшлийн зам талбайд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслийн зогсоолыг байгуулан эзэмшиж байгаа төр, хувь хүн, хуулийн этгээдийг;
- 3.1.10. “Зогсоолын гэрчилгээ” гэж өөрийн болон нийтийн эзэмшлийн газрыг тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар ашиглахаар холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан баримт бичгийг;
- 3.1.11. “Зогсоолын үндсэн төлбөр” гэж холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу үйлчлүүлэгчдийн тээврийн хэрэгслийг тодорхой хугацаагаар байрлуулсан болон хадгалсан хугацаанд оногдуулсан мөнгөн дүнг;

## **Дөрөв.Зогсоолын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын эрх үүрэг**

### **4.1. Зогсоолын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын эрх.**

- 4.1.1. Холбогдох хууль, тогтоомж болон авто зогсоолын норм, стандарт, энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд тодотгол, өөрчлөлт оруулах санал гаргаж шийдвэрлүүлэх.
- 4.1.2. Нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлэх.
- 4.1.3. Засвар, арчлалт хамгаалалттай холбоотой зардлыг Нийслэлийн төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх.
- 4.1.4. Зогсоолын үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, журмыг зөрчсөн тохиолдолд дангаараа гэрээг цуцлах.
- 4.1.5. Зогсоолын үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох.
- 4.1.6. Зогсоолын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлага хүргүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангуулах.
- 4.1.7. Нэгдсэн удирдлагын системд шаардлагатай дата мэдээллийг зогсоолын үйл ажиллагаа эрхлэгчээс тогтоосон хугацаанд авах, шаардах.
- 4.1.8. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтэд үйлчлэх тээврийн хэрэгслийн зогсоолын зориулалтаар батлагдсан барилга, зам талбай дахь төвлөрсөн ил болон дотор зогсоол, гудамж зам дагуух зогсоолуудад байрлуулсан хяналтын камераар фото зураг авах, видео бичлэг хийх, мэдээлэл авах.
- 4.1.9. Хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг илрүүлэх, бүртгэх.

### **4.2. Зогсоолын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг.**

- 4.2.1. Нэгдсэн удирдлагын системтэй холбоотой мэдээ мэдээллээр удирдах дээд шатны байгууллагыг хангах.

- 4.2.2. Хөрөнгө оруулалт, сангийн бүрдүүлэлт, цагийн хуваарь, үйлчилгээний үнэ тариф, хэрэгжилтийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тайлагнан мэдээлэх.
- 4.2.3. Төлбөрийг олон хэлбэрээр төлөх боломжийг бүрдүүлсэн төлбөрийн систем бий болгох.
- 4.2.4. Зогсоолын талбай, дүүргэлт, багтаамжийн мэдээллийг гудамж, зам талбайд байршуулсан электрон дэлгэц болон гар утас, таблет зэргээр дамжуулан мэдээлэл холбооны технологийг ашиглан хэрэглэгчдэд хүргэх.
- 4.2.5. Зогсоолын удирдлагын нэгдсэн системийн мэдээлэл нь нэг загвар, форматтай байхаар мэдээллийн бааз, сервер, аппликэйшн, программ хангамжийг бүрдүүлж, бий болгох.
- 4.2.6. Зогсоолын үйлчилгээ эрхлэгч байгууллагаар (Ангилал ба ерөнхий шаардлага. MNS 5342:2007, Авто үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага. -MNS 5025:2020, хотын стандарт-UCS 0902B:2020 стандарт, БНБД21-05 -10, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм. БНБД30-01 -04, Хот, суурины гудамж, зам төлөвлөлт. БНБД32-01-06, Авто зам төсөвлөх. ЗЗБНБД 22-004-2016 гэх мэт)-ийг мөрдүүлэх.
- 4.2.7. Зогсоолын асуудлаар шинэ техник технологи, инновац нэвтрүүлэх, судалгаа, шинжилгээ хийх.
- 4.2.8. Зогсоолын үйлчилгээний талбайн эрэлт хэрэгцээг тооцож судалгааг гаргах.

## **Тав. Зогсоолын үйл ажиллагаа эрхлэгчийн эрх үүрэг**

### **5.1. Үйл ажиллагаа эрхлэгчийн эрх.**

- 5.1.1. Хэрэгжүүлэгч байгууллагаас зогсоолын стратеги бодлого, төлөвлөлт, стандарт, холбогдох эрх зүйн актыг гаргуулах.
- 5.1.2. Зогсоол ажиллуулах стандарт, норм, дүрэм, журам, техник технологийн шаардлага, хэрэгжүүлэгч байгууллагаас тогтоосон баримт бичгийг бүрэн хангасан тохиолдолд гэрээ байгуулах.
- 5.1.3. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай программ хангамж, удирдлагын нэгдсэн системийн найдвартай ажиллагааг хангуулах.
- 5.1.4. Зогсоолын удирдлагын нэгдсэн системийн үйл ажиллагаа, программ хангамжийн сайжруулалт, зогсоолын талаар санал, хүсэлт гаргах.
- 5.1.5. Тээврийн хэрэгслийн зогсоолын техникийн нөхцөл, шаардлагыг хангахгүй, галын болон бусад төрлийн аюултай, даац хэтрүүлсэн тээврийн хэрэгсэлд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах
- 5.1.6. Үйлчлүүлэгчээс зогсоолын дүрэм, журам, стандартыг мөрдөхийг шаардах.
- 5.1.7. Үйлчлүүлэгчээс зогсоолын төлбөр авах.
- 5.1.8. Иргэд үйлчлүүлэгчдэд хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хөнгөлөлт үзүүлэх.

## **5.2. Үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг.**

- 5.2.1. Зогсоолын үйлчилгээг холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу эрхлэх.
- 5.2.2. Галын болон түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн албан үүргээ гүйцэтгэх нөхцөл, зогсоолын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор зогсоолын дүүргэлтийг 85% -иас хэтрүүлэхгүй.
- 5.2.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас баталсан зогсоолтой холбоотой хэм хэмжээ тогтоосон актыг дагаж мөрдөх.
- 5.2.4. Зогсоолын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлэгч байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх.
- 5.2.5. Хэрэгжүүлэгч байгууллагад сар, улирал, жилээр үйл ажиллагааны тайлан мэдээ гаргаж өгөх.
- 5.2.6. Төлбөр төлөх олон хэлбэрийн нөхцөлийг бүрдүүлж, үүнтэй холбогдон батлагдсан хууль тогтоомжийг мөрдөх.
- 5.2.7. Батлагдсан зургийн дагуу байгуулсан зогсоолыг өөрчлөх, зориулалтын бус тоноглолоор тоноглохгүй байх.
- 5.2.8. Батлагдсан цагийн хуваарийн дагуу ажиллах.
- 5.2.9. Зогсоолын тохижилтын асуудлыг бүрэн хариуцаж шаардлагатай засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэж байх.
- 5.2.10. Зогсоолд байршуулсан тээврийн хэрэгслийн аюулгүй бүрэн бүтэн байдлыг хангах.
- 5.2.11. Иргэд үйлчлүүлэгчдээс гаргасан санал гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх.

## **Зургаа. Зогсоолоор үйлчлүүлэгчийн эрх үүрэг**

### **6.1. Үйлчлүүлэгчийн эрх.**

- 6.1.1. Үйлчлүүлэгч нь тээврийн хэрэгслийн техникийн нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангасан зогсоолоор үйлчлүүлэх.
- 6.1.2. Зогсоолын үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл авах, урьдчилсан захиалга өгөх, цуцлах.
- 6.1.3. Төлбөрийн олон талт хэлбэрээр үйлчлүүлэх.
- 6.1.4. Зогсоолтой холбоотой санал, гомдол, хүсэлт гаргах.

### **6.2. Үйлчлүүлэгчийн үүрэг.**

- 6.2.1 Төлбөртэй зогсоолоор үйлчлүүлэгчийн тээврийн хэрэгсэл нь татвар, торгууль, төлбөр, хураамж болон бусад зөрчилгүй байна.
- 6.2.2 Зогсоол, түүнтэй холбогдон батлагдсан хууль тогтоомжийг дагаж мөрдөх
- 6.2.3 Зогсоолын тэмдэг, тэмдэглэгээний дагуу тээврийн хэрэгслийг байрлуулах

6.2.4 Зогсоол болон бусад үйлчилгээний төлбөрийг төлөх.

6.2.5 Зогсоолын техникийн нөхцөл, шаардлагыг хангахгүй, галын болон бусад төрлийн аюултай ачаатай үйлчлүүлэхгүй байх.

### **Долоо. Төлбөр төлөх зарчим, аргачлал**

7.1 Зогсоолын төлбөрийн систем нь цахим байна

7.2 Зогсоолын үндсэн төлбөр нь бүрэн ба бүрэн бус минутаар тооцогдох бөгөөд эхний 15 минут төлбөргүй байна.

7.3 Зогсоолын төлбөрийг урьдчилсан болон дараа төлбөрийн зарчмаар төлж барагдуулна.

7.4 Урьдчилсан төлбөрийн зарчим нь энэхүү журмын 7.2-д заасан нөхцөлд суурилна.

7.4.1 Урьдчилсан төлбөрт зарчим нь хөнгөлөлт, урамшуулалтай байж болно.

7.5 Дараа төлбөрийн зарчим нь дараах нөхцөлтэй байна.

7.5.1 Зогсоолын үндсэн төлбөрийг ажлын 1-10 хоногт барагдуулбал 2 дахин нэмэгдүүлж төлнө.

7.5.2 Зогсоолын үндсэн төлбөрийг ажлын 11-20 хоногт барагдуулбал 4 дахин нэмэгдүүлж төлнө.

7.5.3 Ажлын 21 хоногоос дээш хугацаанд төлбөрөө төлж барагдуулаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу арга хэмжээ авна.

7.6 “Гудамж зам дагуух хаалтгүй зогсоол”-д байрлуулсан тээврийн хэрэгслийн эхэлсэн болон дууссан цагийг бүртгүүлээгүй бол төлбөрийг бүтэн өдрөөр буюу ажлын 8 цагаар ногдуулж тооцно.

### **Найм. Хариуцлага**

8.1 Энэхүү журам, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн хувь хүн, албан тушаалтан, хуулийн этгээд хариуцлага хүлээнэ.

8.2 Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь зөрчлийг хянан шийдвэрлэж хариуцлага ноогдуулна.

### **Ес.Бусад зүйл**

9.1 Энэхүү журамд тусгагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.2 Журмыг 2022 оны ... дугаар сарын ... ны өдрөөс дагаж мөрдөнө.